



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/153

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 дэх заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны төсөв батлах тухай 25/113 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын “2025 оны А/1393 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 1, 3, 13, 14-р байрны гадна талбайн тохижилтын засварын ажлын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газрын Хот тохижилтын хэлтэс (Б.Даваабаяр)-т, гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар (Г.Билгүүн)-т үүрэг болгосугай.

3.Хавсралтаар батлагдсан ажилд шаардагдах 479,586,037 (Дөрвөн зуун далан есөн сая таван зуун наян зургаан мянга гучин долоо) төгрөгийг Хот тохижилтын бусад зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА Г.БАТЗОРИГ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2025 оны 10 дугаар сарын 17 ны өдрийн  
11/153 тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 1-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙРЛАХ 1, 3, 13, 14-Р БАЙРНЫ ГАДНА ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН ЗАСВАРЫН  
АЖЛЫН ЗАРДАЛ

| №    | Төсөл арга хэмжээний нэр,<br>хүчин чадал, байршил                                                                                                           | Хугацаа |        | Төсөвт<br>өртөг | Санхүүжих<br>дүн<br>(сая.төг) |
|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------|-----------------|-------------------------------|
|      |                                                                                                                                                             | Эхлэх   | Дуусах |                 |                               |
| 1    | 2                                                                                                                                                           | 3       | 4      | 5               | 6                             |
| 1    | Улаанбаатар хот,<br>Чингэлтэй дүүрэг 1-р<br>хорооны нутаг дэвсгэрт<br>байрлах 1, 3, 13, 14-р<br>байрны гадна талбайн<br>тохижилтын засварын<br>ажлын зардал | 2025    | 2025   | 479,586,037     | 479,586,037                   |
| Нийт |                                                                                                                                                             |         |        | 479,586,037     | 479,586,037                   |

ᐅᓂᕈᕋᓂ ᐱᓄᓂ ᐸᓇᓂ ᐸᓇᓂ ᐸᓇᓂ ᐸᓇᓂ ᐸᓇᓂ

לשון אלהים